



**Аудитын код: САГ-2018/76/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо  
Утас: 261740 Цахим хаяг: [ichinkhorloosh@audit.gov.mn](mailto:ichinkhorloosh@audit.gov.mn)

Улаанбаатар хот



## АГУУЛГА

---

1	Аудитын гэрчилгээ .....	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт .....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	4
2.9.1	Түлш шатахууны бүртгэлийн талаар.....	4
2.9.2	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухайхуулийнхэрэгжилтийнталаар.....	4
2.9.3	Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын дүрмийн хэрэгжилтийн талаар.....	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	6
3	Менежментийн захидал.....	7
3.1	Түлш шатахууны бүртгэлийн талаар.....	8
3.2	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар.....	9
3.3	Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын дүрмийн хэрэгжилтийн талаар.....	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	11
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийгдсэн орлогын тайлан .....	12
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/692  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЦАГДААГИЙН "ЦАГААН ШОНХОР"  
ТӨУҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.АРИУНЗАЯА  
ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цагдаагийн "Цагаан шонхор" ТӨУҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Цагдаагийн "Цагаан шонхор" ТӨУҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагдаагийн "Цагаан шонхор" ТӨУҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kherreg\Yawsan\_Bichig\2018\0315SAG27.Docx

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## Үүрэг, хариуцлага

Цагдаагийн "Цагаан шонхор" ТӨУҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд түлш шатахууны бүртгэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын дүрмийн хэрэгжилтийн талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 24-нөөс 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 14-нд эцэслэн баталгаажуулж, Үндэсний аудитын газарт хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор Ч.Эрдэнэжав нар хариуцаж хэрэгжүүлэв.



Аудитаар Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 39 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### **2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад эрхзүйн актуудыг мөрдөж байна.

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын эрхэм зорилго нь 1992 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас хэрэглэл бэлтгэн нийлүүлэх зорилгын хүрээнд ажиллаж байна.

Тус үйлдвэр нь орчин үеийн оёдлын 60 гаруй тоног төхөөрөмжтэй, 80 гаруй ажилтан ажиллагсадтайгаар жилдээ 20 гаруй мянган хос хувцас үйлдвэрлэх хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд 8.6 мянган хос дүрэмт хувцас үйлдвэрлэсэн.

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан. Мөн төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

### **2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГАЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 31 горим, сорил гүйцэтгэв.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ нь санхүүгийн тайлангаа “Инфосистем” ХХК-ийн “Макс” програм хангамжаар бэлтгэсэн байна.





## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын алба байхгүй, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд илэрч байна.

## 2.6 Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 279 дугаар тогтоолоор Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталгаажуулжээ.

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 625.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.

“Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны борлуулалтын орлогыг дараах хүснэгтээр үзүүлэв.


Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт
Үндсэн үйл ажиллагааны орлого	550.0	624.9	74.9
Бусад орлого		0.07	0.07
Хүүгийн орлого		0.9	0.9
<b>НИЙТ</b>	<b>550.0</b>	<b>625.9</b>	<b>75.9</b>

/сая.төг/

Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 112.0 сая төгрөг, нийт үйл ажиллагааны зардалд 470.8 сая төгрөгийг зарцуулан ажилласан. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон нийт зардлыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Зардлын нэр	2016 он	2017 он	Өөрчлөлт
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	463.5	112.0	-351.5
Борлуулалт, маркетингийн зардал		6.2	6.2
Ерөнхий ба удирдлагын зардал	464.2	448.0	16.1
Бусад зардал	2.0	16.5	-14.5
<b>НИЙТ</b>	<b>929.8</b>	<b>582.8</b>	<b>343.6</b>

/сая.төг/



## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨҮГ нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан боловч 1-10 дугаар сар, 12 дугаар сард хоцроон тайланг оруулсан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын нийт 31 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад горим сорил хэрэгжүүлсний үндсэн дээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинж чанартай 3 алдааг олж тогтоосноос материаллаг бус 1 алдаа, материаллаг 2 алдааг илрүүлснийг ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүллээ.

### 2.9.1 Түлш шатахууны бүртгэлийн талаар

Сангийн Сайдын 2014 оны 249 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ыг мөрдөөгүй 6,7 сая төгрөгийн шатахууныг шууд зардлын дансанд бүртгэж тайлагнасан байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Сангийн Сайдын баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу түлш шатахууны зарцуулалтын тайлан гаргаж, жолоочийн тооцоог бодож, хэмнэлт болон хэтрэлтийг тооцож хэвшихийг менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

### 2.9.2 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1-т “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, шинэчлэх тогтоол гаргах” гэж зааснаар Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2016 оны 04 тоот тогтоолоор батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрээгүй, давхардсан тоогоор 50 ажилтанд 2.8 сая төгрөгийн цалинг дутуу олгосон байна. Энэ нь цагийн бүртгэлийг цагаар нь нарийвчлан бүртгэхгүйгээр өдрөөр бүртгэж тайлагнаж байгаатай холбоотой байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг мөрдөж цагийн бүртгэл болон цалин хөлс бодолтын арга ажиллагааг өөрийн онцлогт тохируулж боловсронгуй болгох, алдааг давтан гаргахгүй ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж өгөв.





### 2.9.3 Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын дүрмийн хэрэгжилтийн талаар:

Тус үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан дүрмийг зөрчиж, дотоод хяналтын тогтолцоог зохион байгуулаагүй, мэргэшсэн нягтлан бодогчгүй ажилласан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 255 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Үйлдвэрийн газар нь санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байх бөгөөд дотоод хяналт тавих журмыг захирал батална”, 8 дугаар зүйлийн 8.3-т “Үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь Мэргэшсэн нягтлан бодогч байна” гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Тус үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан дүрмийн дагуу дотоод хяналтын тогтолцоог бий болгож зохион байгуулах, мэргэшсэн нягтлан бодогчтой болж алдааг давтан гаргахгүй байхаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

### 2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудлыг аудитын гүйцэтгэлийн шатанд тодруулахад Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ нь “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэн явуулж Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулна” гэж заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлэх эсэхийг Татварын ерөнхий газраас тодруулах шаардлагатай байна.

### 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар Цагдаагийн ерөнхий газрын Санхүү хангамжийн газраас цагдаагийн хувцасны материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бараа материал, өр төлбөрийн дансанд бүртгэдэг нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан зааврын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцох боломжгүй байгаа асуудлыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### 2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 35.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 26.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулан, 9.6 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### 2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 2 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### 2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын тайлангийн зардлын дүнг сонгов.

Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны орлогын тайлангийн нийт зардал 444.6 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨВЛӨМЖИЙН  
САНАД ДҮГНЭЛТ

## 2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлого, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт гаргалаа.

### “ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ” ХХК-ИЙН:

ХОЁР ДАХЬ ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР:

Э.ХҮРЭЛТОГОО

АНХАН ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

ЗАХИРАЛ

Ц.БЯМБАЖАВ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭЖАВ

АУДИТОРЫН ТУСЛАХ

Ш.БЯМБАСҮРЭН



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



<p><b>3.1 Түлш шатахууны бүртгэлийн талаар</b></p>	<p><b>Тэргүүлэх ач холбогдол №1</b></p>
--	---

**ҮАГ-ын ажиглалт**

Сангийн сайдын 2014 оны 249 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу 6.7 сая төгрөгийн шатахууныг шууд зардлын дансанд бүртгэж тайлагнасан.

**ҮАГ-ын зөвлөмж**

Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу түлш шатахууны зарцуулалтын тайлан гаргаж, жолоочийн тооцоог бодож, хэмнэлт болон хэтрэлтийг тооцож хэвших.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25 өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр мэдэгдэх.

**Эрсдэлүүд**

Тохиолдсон байхбатламж мэдэгдэл хангагдахгүй байх, холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх эрсдэл үүсч байна.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг асуудлын бүртгэлээр удирдлага хүлээн зөвшөөрсөн.



<b>3.2 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №2</b>
---	----------------------------------

**ҮАГ-ын ажиглалт**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1-т “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, шинэчлэх тогтоол гаргах” гэж зааснаар Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2016 оны 04 тоот тогтоолоор батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрээгүй, давхардсан тоогоор 50 ажилтанд 2.8 сая төгрөгийн цалинг дутуу олгосон байна. Энэ нь цагийн бүртгэлийг цагаар нь нарийвчлан бүртгэхгүйгээр өдрөөр бүртгэж тайлагнаж байгаатай холбоотой байна.

**Эрсдэлүүд**

Хэмжилт ба үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх, хууль эрх зүйн актууд зөрчигдөх эрсдэл үүсч байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг мөрдөж цагийн бүртгэлийг цагаар бүртгэн цалин хөлсөө тооцохыг зөвлөж байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25 өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр мэдэгдэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг асуудлын бүртгэлээр удирдлага хүлээн зөвшөөрсөн.



<b>3.3 Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын дүрмийн хэрэгжилтийн талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №3</b>
--	----------------------------------

**ҮАГ-ын ажиглалт**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 255 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Цагдаагийн “Цагаан шонхор” ТӨУҮГ-ын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Үйлдвэрийн газар нь санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байх, бөгөөд дотоод хяналт тавих журмыг захирал батална” гэж заасныг зөрчиж дотоод хяналтын тогтолцоогүй, хяналтын нэгжгүй, ажиллаж байна.

Тус үйлдвэрийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь Мэргэшсэн нягтлан бодогч байна” гэж заасныг зөрчиж, мэргэшсэн нягтлан бодогчгүй ажиллаж байна.

Тус үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан дүрмийг зөрчиж, дотоод хяналтын тогтолцоогүй, мэргэшсэн нягтлан бодогчгүй ажилласан байна.

**Эрсдэлүүд**

Өмч хөрөнгө шамшигдах, хариуцлагын тогтолцоо алдагдах нягтлан бодогчийн дадлага туршлага муугаас бодлогын шинжтэй бүртгэлийн алдаа гарах, эрсдэл үүсч байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Тус үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан дүрмийн дагуу дотоод хяналтын тогтолцоог бий болгож, мэргэшсэн нягтлан бодогчтой болох.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр мэдэгдэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг удирдлага асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн.





**ЦАГДААГИЙН "ЦАГААН ШОНХОР" ТӨУҮГ  
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2017 оны 12 сарын 31 өдөр**

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
	өмнөх оны	тайлант оны
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	271,114.06	113,211,091.39
Дансны авлага		
Татвар, НДШ - ийн авлага		
Бусад авлага		
Бараа материал	41,862,482.84	56,706,508.99
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		1,500,000.00
<b><u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u></b>	<b><u>42,133,596.90</u></b>	<b><u>171,417,600.38</u></b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	169,895,205.54	154,618,776.10
Биет бус хөрөнгө	592,152.27	1,618,818.94
Биологийн хөрөнгө		
<b><u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u></b>	<b><u>170,487,357.81</u></b>	<b><u>156,237,595.04</u></b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>212,620,954.71</b>	<b>327,655,195.42</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
Дансны өглөг	69,981,805.00	25,534,005.00
Цалингийн өглөг		
Татварын өр	11,132,235.81	8,097,767.59
НДШ- ийн өглөг		
Урьдчилж орсон орлого		125,400,000.00
<b><u>Өр төлбөрийн нийт дүн</u></b>	<b><u>81,114,040.81</u></b>	<b><u>159,031,772.59</u></b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч: -төрийн	59,469,098.00	59,469,098.00
Хуримтлагдсан ашиг	72,037,815.90	109,154,324.84
<b><u>Эздийн өмчийн дүн</u></b>	<b><u>131,506,913.90</u></b>	<b><u>168,623,422.84</u></b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>212,620,954.71</b>	<b>327,655,195.43</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**ЦАГДААГИЙН "ЦАГААН ШОНХОР" ТӨУҮГ  
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН  
2017 оны 12 сарын 31 өдөр**

(төгрөгөөр)

<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>ӨМНӨХ ОНЫ</b>	<b>ТАЙЛАНТ ОНЫ</b>
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	960,456,639.67	624,972,180.00
Борлуулалтын өртөг	463,553,172.58	112,015,814.11
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<u>496,903,467.09</u>	<u>512,956,365.89</u>
Түрээсийн орлого		
Хүүний орлого		912,096.61
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		75,000.00
Борлуулалт, маркетингийн зардал		6,239,633.33
Ерөнхий ба удирдлагын зардал	464,226,412.83	448,042,772.99
Санхүүгийн зардал		
Бусад зардал	2,076,011.22	16,575,238.00
Гадаад валютын ханшын зөрүүний олз (гарз)		(3,203.62)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<u><b>30,601,043.04</b></u>	<u><b>43,082,614.56</b></u>
Орлогын татварын зардал	3,060,104.30	5,966,105.62
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<u><b>27,540,938.74</b></u>	<u><b>37,116,508.94</b></u>
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<u><b>27,540,938.74</b></u>	<u><b>37,116,508.94</b></u>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**ЦАГДААГИЙН "ЦАГААН ШОНХОР" ТӨУҮГ  
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
2017 оны 12 сарын 31 өдөр**

<b>№</b>	<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>Өмч</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>Нийт дүн</b>
1	2017 оны 01-р сарын 01 -ний үлдэгдэл	59,469,098.00	72,037,815.90	131,506,913.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>			-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		37,116,508.94	37,116,508.94
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-
6	Өмчид гарсан өөрчлөлт			-
7	Зарласан ногдол ашиг			-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
9	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>59,469,098</b>	<b>109,154,324.84</b>	<b>168,623,422.84</b>



**ЦАГДААГИЙН "ЦАГААН ШОНХОР" ТӨУҮГ  
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2017 оны 12 сарын 31 өдөр**

<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>ӨМНӨХ ОНЫ</b>	<b>ТАЙЛАНТ ОНЫ</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	<u>958,129,998.54</u>	<u>758,841,021.77</u>
Бараа борлуулсаны, үйлчилгээ үзүүлсний орлого	953,477,706.96	629,891,169.77
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,462,004.00	3,474,852.00
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	1,190,287.58	125,475,000.00
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	<u>944,892,201.90</u>	<u>629,863,141.05</u>
Ажиллагчдад төлсөн	267,356,372.18	253,441,077.68
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	64,249,802.75	56,316,468.35
Бараа материал худалдан авахад төлсөн	508,196,775.00	201,661,819.78
Ашиглалтын зардалд төлсөн	9,479,127.30	5,428,258.75
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,161,630.00	6,734,103.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	30,400,020.00	37,843,406.16
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	61,048,474.67	68,438,007.33
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b><u>13,237,796.64</u></b>	<b><u>128,977,880.72</u></b>
<b>Хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	<u>-</u>	<u>912,096.61</u>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүний орлого		912,096.61
Хүлээн авсан ногдол ашиг		
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	<u>56,375,840.00</u>	<u>16,950,000.00</u>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	56,375,840.00	13,800,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,650,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b><u>(56,375,840.00)</u></b>	<b><u>(16,037,903.39)</u></b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	<u>1,620,000.00</u>	<u>59,700,615.62</u>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,620,000.00	59,700,615.62
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	<u>1,620,000.00</u>	<u>59,700,615.62</u>
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,620,000.00	59,700,615.62
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>43,409,157.42</b>	<b>271,114.06</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b><u>271,114.06</u></b>	<b><u>113,211,091.39</u></b>

